



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 29 өдөр

Дугаар A/114

Булган сум

Г Биеийн тамир, спортын газрын дүрэм,
бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 12 дүгээр сарын 05-ны 529 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны 01/82 тоот албан бичгээр ирүүлсэн бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэлийн дагуу аймгийн Биеийн тамир, спортын газрын дүрмийг 1 дүгээр хавсралтаар, бүтэц орон тоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Биеийн тамир, спортын газрын дарга (Х.Батхишиг), дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д тус тус даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2022 оны A/89 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны
02. дугаар сарын 29-ны өдрийн А/МЖ дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДҮРЭМ,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Биеийн тамир, спортын үйл ажиллагаа, биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого, цогц хөтөлбөр, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах, орон тоо бүтэц зохион байгуулалтыг тогтоож, хэрэгжүүлэх биеийн тамир, спортын үйл ажиллагаа эрхэлж буй төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, хяналт тавих, үнэлгээ өгөхтэй холбогдсон үйл ажиллагаа, харилцааг энэхүү дүрмээр зохицуулна.

Хоёр. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

2.1. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар Төрөөс баримтлах бодлого, шийдвэр, хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх, хяналт тавих, мэргэжил арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэгтэй ажиллана.

2.2. Үйл ажиллагаандaa Биеийн тамир, спортыг хөгжүүлэх, дэмжих талаар гарсан Монгол улсын хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллана.

2.3. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тухайн орон нутгийн нийт ард иргэдэд нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх, Засгийн газрын болон биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр явагдаж байгаа спортын тэмцээн уралдаан болон биеийн тамир, спортын арга хэмжээнүүдийг орон нутгийн хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангана

2.4. Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, орон нутагг үйл ажиллагаа явуулж буй төрийн болон ТББ, ААН, Спортын холбоодууд, биеийн тамир чийрэгжүүлэлтийн клубуудад удирдамж чиглэл өгч, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж хамтран ажиллана.

2.5. Харьяа нутаг дэвсгэрийн биеийн тамир, спортын үйл ажиллагаа эрхэлж буй төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүлэх, чиг үүргийн дагуу зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлж, биелэлтэд нь хяналт тавин ажиллана.

2.6. Нутаг дэвсгэрийн хэмжээнд биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллана.

2.7. Туслах аж ахуйг хөгжүүлэн, тамирчдыг амрах байр, цайны газраар хангаж түүнээс олсон нэмэлт орлогоос ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх чиглэлээр зарцуулж болно. холбогдох эрх зүйн хүрээнд

Гурав. Биеийн тамир, спортын газрын эрх

3.1..Нутаг дэвсгэрийн хэмжээнд биеийн тамир, спортын төрийн болон ТББ-ын үйл ажиллагааг хянан шалгах, зааварлах, үүрэг даалгавар, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч шаардлага тавих

3.2.Биеийн тамир, спортын байгууллагын Тэргүүний ажилтныг, орон нутаг болон төрийн дээд байгууллагын шагналд тодорхойлж, шагнаж урамшуулах

3.3.Өөрийн орны болон гадаадын ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах, гэрээ хэлцэл хийх

3.4.Биеийн тамир, спортын байгууллагын ажилтны нийгмийн асуудлыг судлан шийдвэрлэх, холбогдох асуудлыг зохих шатны байгууллагад тавих

3.5.Хуульд заасан эрхийн хүрээнд ажилтныг томилох, чөлөөлөх, албан тушаалаас бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, түр чөлөөлөх, халах

Дөрөв. Биеийн тамир спортын газрын үүрэг

4.1.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний Хэрэгжүүлэгч агентлаг нь биеийн тамир, спортын асуудлаар Монгол Улсын Их Хурал, Монгол улсын Засгийн газар, Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон биеийн тамир спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, бусад дээд шатны байгууллагаас гаргасан бодлого, шийдвэрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлж, зохицуулах, гүйцэтгэлд хяналт тавих, тайлاغнах

4.2.Биеийн тамир спортын талаар гарсан хууль тогтоомж, хөтөлбөр, биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон биеийн тамир спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн захиргааны байгууллагаас гаргасан эрхийн акт, шаардлагааг дагаж мөрдөнө.

4.3.Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд орон нутаг дангаар болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран гүйцэтгэх биеийн тамир, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээний судалгааг гарган, гэрээгээр хамтран ажиллах, дэмжлэг туслалцаа үзүүлэх

4.4.Хүн амд биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээ үзүүлэх, материаллаг орчин нөхцөлийг бүрдүүлэх, иргэд орон нутгийн удирдлагыг мэргэжил арга зүйгээр хангах

4.5.Орон нутгийн хэмжээнд хүн амыг биеийн тамир спортоор хичээллэж, эрүүл чийрэг бие бялдартай болгох, нийгмийн болон материаллаг орчин нөхцөлийг бүрдүүлэх ажлыг Төрийн болон ТББ-ын оролцоотойгоор зохион байгуулж, хэрэгжүүлэх

4.6.Биеийн тамир, спортын барилга байгууламж, тоног төхөөрөмж хэрэглэл материалын судалгааг гарган төлөвлөлт, зохион байгуулалтыг хийж, шинээр барих, худалдан авах, засвар үйлчилгээг хийх саналыг нэгтгэн зохион байгуулах

4.7.Өөрийн эзэмшиж буй төрийн өмчийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналт тавьж, үйл ажиллагааны нэр төрлөөр өртөг зардлыг тооцон, нэгж үйлчилгээнд зарцуулж буй бүтээгдэхүүнд суурисан өртгөөр дараа оны төсвийг боловсруулж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж тайлагнах

4.8.Биеийн тамир спортын хөгжлийн хэтийн болон ойрын стратеги төлөвлөгөөг боловсруулан, Аймгийн Засаг даргын удирдлагын багын хурлаар батлуулан мөрдөж ажиллах

4.9. Спортын уралдаан тэмцээнд орчин үеийн анагаах ухаан, эрдэм шинжилгээний ололтыг нэвтрүүлэх, тухайн орон нутгийн онцлогт тохирсон спортын төрлүүдийг тулхуу хөгжүүлэн

4.10. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг Биеийн тамир, спортын газрын даргын тушаалаар томилсон /цаашид дотоод хяналт шалгалтын нэгж ажилтан гэх/ гүйцэтгэн дунг тайлагнана.

4.11. Биеийн тамир, спортын газар нь үйл ажиллагааныхаа тайланг Аймгийн Засаг даргад тайлагнана.

4.12. Биеийн тамирын багш, орон тооны бус арга зүйчдийг удирдлага арга зүйгээр хангаж ажиллана.

Тав. Удирдлага зохион байгуулалт

5.1. Биеийн тамир, спортын байгууллага нь санхүү аж ахуйн хувьд биеэ даасан хуулийн этгээд байна.

5.2. Биеийн тамир, спортын газрын дарга нь Төсвийн ерөнхийлөн захирагч ТБУСТХ-ийн дагуу эрхээ шилжүүлсний дагуу Аймгийн Засаг даргатай гүйцэтгэлийн гэрээ байгуулан ажиллана.

5.3. Биеийн тамир, спортын газар нь харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд биеийн тамир спортын ажил үйлчилгээ, төрийн хууль тогтоомжийн хэрэгжилт, хүний нөөцийн бодлого, бүтэц зохион байгуулалт үйл ажиллагааг боловсронгуй болгох, санхүү хөрөнгө нөөцийн төлөвлөлт хувиарлалт, түүнд хяналт тавих асуудлыг хариуцаж, Аймгийн Засаг дарга болон БТСГ-аар дамжуулан Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргад тайлагнана.

5.4. Биеийн тамир, спортын газрын бүтэц орон тоо, үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийг Аймгийн Засаг дарга батална.

5.5. Биеийн тамир, спортын газар нь Нийтийн биеийн тамир, спортын сургалт дасгалжуулалт, Захиргаа аж ахуй гэсэн 2 албатай үйл ажиллагаа явуулна.

Зургаа. Нийтийн биеийн тамир, спортын сургалт дасгалжуулалтын албаны үүрэг

6.1. Биеийн тамир, чийрэгжүүлэлт, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах

6.2. Нийтийн биеийн тамир, эрүүл аж төрөх дадал хэвшил, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт сурталчилгаа хийх

6.3. Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох, дунг нэгтгэн цахимжуулан түүний мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөрийг гарган, хэрэгжүүлэх

6.4. Нутаг дэвсгэрийн биеийн тамир, спортын үйл ажиллагаа эрхэлж буй ТББ болон нийт хүн амд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, нэгдсэн удирдлагаар хангах

6.5. Спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих

6.6. Орон нутгийн онцлогийг харгалзан хөгжиж буй спортын төрлүүдийг дэмжиж, шинээр хөгжих боломжтой спортын төрлүүдийг судлан бодлогыг тодорхойлж, төлөвлөн хэрэгжүүлэх, зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангах

6.7. Аймгийн Засаг дарга нь биеийн тамир, спортыг дэмжиж, тамирчдын залгамж халаа, өсвөрийн шигшээ багийг байгуулан, үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг зохион байгуулах

6.8. Үндэсний спортыг орон нутагт хөгжүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах

6.9. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөрийн биелэлтийг тооцон, төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангах

Долоо. Захиргаа аж ахуйн албаны үүрэг

7.1. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх

7.2. Байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах, төсвийн төлөвлөлт, хувиарлалт, зарцуулалт, бүртгэлд хяналт тавих

7.3. Биеийн тамир, спортын барилга байгууламж, тоног төхөөрөмж хэрэглэл материалын ашиглалт, хадгалалтад хяналт тавих, хангамж, нөөцийн судалгааг гаргах, эдийн засгийн төлөвлөлт, зохион байгуулалтыг хийх

Найм.Бусад

8.1. Энэхүү дүрэмд Аймгийн Засаг даргын захирамжаар өөрчлөн, шинэчлэн батална.

Аймгийн Засаг даргын 2024 оны
оны 2.9-ны өдрийн 20/11 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН БҮТЭЦ ОРОН ТОО

ГАЗРЫН ДАРГА

Төрийн
захиргааны

Биөийн тамирын хэлтэс

Спортын хэлтэс

- 1.Хяналт шинжилгээ, үнэлгээ, хүний нөөц, тайлан мэдээ хариуцсан ахлах мэргэжилтэн-1 (ТЗ-8)
 - 2.Мэдээллийн цахим сан, статистик хариуцсан мэргэжилтэн -1 (ТЗ-9)
 - 3.Нягтлан бодогч-1 (ТҮ-8)
 - 4.Эмч -1 (ТҮЭМ-5)
 - 5.Усны инженер, слесарь-1 (ТҮ-6)
 - 6.Архив, бичиг хэргийн эрхлэгч-1 (ТҮ-5)
 7. Нярав-1
 8. Харуул-5
 - 9.Жолооч-1
 - 10.Үйлчлэгч -4 Нийт:18

- 1.Биөийн тамирын хэлтсийн дарга-1 (ТЗ-6)
 - 2.Биөийн тамирын арга зүйч-3 (ТҮСБ-4)
Нийт: 4

1. Спортын хэлтсийн дарга-1
(ТЗ-6)
 1. Бөхийн төрлийн
дасгалжуулагч-1 (ТҮСБ-4)
 2. Спорт тоглоом,
хэмжигдэхүүнтэй спортын
дасгалжуулагч-1 (ТҮСБ-4)

Бүгд-25